



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/512

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багт баригдсан “Гэр хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /ДДТөв-8-II хэлхээ/ 3.5 км 63 ширхэг дулааны худаг”. 7,13 дугаар багийн 2, 3 дугаар хэсгийн /9.2 км, 272 ширхэг бохирын худаг/ Ариутгах татуургын шугам. 2, 3, 4 дүгээр багийн /7.6км, 232 ширхэг бохирын худаг/ Ариутгах татуургын шугамын ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Тулга (Барилгын хөгжлийн төвийн ББЗХХэлтсийн хяналтын инженер)

Д.Сандагдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитекторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Мягмарсүрэн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)

Д.Аюушжав (Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын архитектор, дэд бүтэц нийтийн тээвэр хариуцсан ажилтан)

Б.Ганзориг (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ж.Ганболд (“МОН-КУЗБАСС” ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Н.Бямбадорж (“Энерготех Сервис” ХХК-ийн захирал)
Э.Ганхуяг (“Энерготех Сервис” ХХК-ийн инженер)

Туслан гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Г.Бадамдорж (“ЭВ УХАТ” ХХК-ийн захирал)
Г.Энхбаяр (“ЭВ УХАТ” ХХК-ийн Ерөнхий инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Ш.Нямханд (Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн ерөнхий инженер)
Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ